



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/Ч10

Улаанбаатар хот

Цэцэрлэгийн насны хөгжлийн
бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих
төвийг турших тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.11, 5.1.13 дахь заалт, Боловсролын ерөнхий хуулийн 17.8, 17.9 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/220, А/475, А/812 дугаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц дэмжлэг үзүүлэх аргачлал, маягт шинэчлэн батлах” тухай хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа шаардлагатай цэцэрлэгийн насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг 2023-2024 оны хичээлийн жилд “Энэрлийн түүчээ” төрийн бус байгууллагын дэргэдэх “Хүслийн ордон” цэцэрлэгийг түшиглэн туршилтаар зохион байгуулсугай.


2. Туршилтын үйл ажиллагааны 2023 оны 9-12 дугаар сард шаардагдах зардлыг хавсралт ёсоор баталсугай.

3. Батлагдсан зардал болох 50,369,524 (тавин сая гурван зуун жаран есөн мянга таван зуун хорин дөрөв) төгрөгийг “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслөөс санхүүжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Б.Батцэцэг)-т зөвшөөрсүгэй.

4. Туршилтын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган хамтран ажиллаж, үр дүнг 2023 оны 12 дугаар сарын 10-ны дотор танилцуулахыг Тэгш хамран сургах боловсролын хэлтэс, Сургуулийн өмнөх боловсролын хэлтэс (Ж.Мягмар), Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т тус тус даалгасугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (Л.Төгсбаяр)-т даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

14231 1532

Боловсрол шинжлэх ухааны сайдын
2023 оны 10 сарын 06 өдрийн
... дугаар тушаалын
... дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

ТӨВИЙН 2023 ОНЫ 9-12 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ШААРДАГДАХ ЗАРДАЛ

№	Санхүүжилтийн төрөл	Хэмжих нэгж	Сард зарцуулах зардал	Хугацаа (сараар)	Нийт зардал
1	Хоолны зардал (МУЗГ-ын 2022 оны 498 дугаар тогтоолд зааснаар, нийт хүүхдийн тоо 44)	3600₮	3,484,800₮	4	13,939,200₮
2	Байрны түрээс (“Дэмжих төв”-ийн 97.8м2 талбай)	m2 – 9000₮	880.200₮	4	3,520,800₮
3	Явуулын багшийн нэмэлт үйлчилгээний зардал (Явуулын 2 багшийн үйлчилгээний шатахууны зардал. Тахилт, Баянхошуу, 22-ын товчоо)	-	380.000₮	4	1,520,000₮
4	Туршилтын төвд ажиллах ажилтны цалин, нэмэгдэл хөлс (Багш 2, сэтгэл зүйч 1, туслах багш 3)	-	7,311,000₮	4	31,389,524₮
					50,369,524₮